



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 15

Мандалговь

Үндсэн хөрөнгөд үнэлгээ тогтоож,
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арвангуравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 13,200,000 /арван гурван сая хоёр зуун мянга/ төгрөгийн балансын үнэтэй үлдэгдэл өртөггүй Shandong-LG918 маркийн тусгай зориулалтын тээврийн хэрэгслийн худалдах доод үнийг 2,000,000 /хоёр сая/ төгрөгөөр тогтоон нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Адъяасүрэн), Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэх;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;


2.3 Тогтоолын биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн
15 дугаар тогтоолын хавсралт



Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газрын худалдах тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон огноо	Тээврийн хэрэгслийн		Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Худалдах доод үнэ
			Сери	Дугаар			Арлын дугаар	Моторын дугаар					
1	Ачигч. Урдаа шангатай КОВШ	Shandong LG918	-	-	2015	2016/10/01	A9161505228			13.200.000	13.200.000	0	2000,000
Нийт													2,000,000 /хоёр сая/ төгрөг